



## МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2018 оны 11 сарын 29 өдөр

Дугаар А/132

Улаанбаатар хот

### Гишүүний эрхийг сэргээх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.10.11, Гишүүнчлэлийн журмын 5 дугаар зүйлийн 5.3.1, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК болон “Ди Си Эф ҮЦК” ХХК-ийн хооронд хамтран байгуулсан 2018/93 дугаартай “Гишүүний хураамжийн төлбөрийг барагдуулах гэрээ”-г тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Гүйцэтгэх захирлын 2017 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн А/214 дугаартай тушаалаар гишүүний эрхийг түдгэлзүүлсэн “Ди Си Эф ҮЦК” ХХК-ийн гишүүний эрхийг сэргээсүгэй.
2. “Ди Си Эф ҮЦК” ХХК-ийн арилжаанд оролцох эрхтэй ажилтан /Б.Нарангэрэл/-ийн арилжааны системд нэвтрэх эрхийг сэргээж нэвтрэх нэр, нууц үгийг шинээр олгосугай.
3. Арилжаанд оролцох эрх авсан гишүүн ҮЦК-ийн ажилтанд Монгол улсын үнэт цаасны зах зээлд мөрдөгдөж буй хууль, тогтоомж, журам, зааврыг үйл ажиллагаандаа чанд мөрдөж, өндөр хариуцлага, ёс зүйтэй ажиллахыг үүрэг болгосугай.
4. Цаашид хууль тогтоомж, журам заавар болон “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанитай байгуулсан “Гишүүнчлэлийн гэрээ”-гээр хүлээсэн үүргээ тогтмол биелүүлэн ажиллахыг “Ди Си Эф ҮЦК” ХХК-ийн гүйцэтгэх захирал /Т.Жигмэддагва/-д анхааруулсугай.
5. Үнэт цаасны арилжааны програмд нэвтрэх эрх сэргээхийг Үйл ажиллагааны газрын Арилжааны алба /Д.Алдармаа/-нд, тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт, зохицуулалтын газрын Хяналт шинжилгээний алба /Д.Баттулга/-нд тус тус үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Х.АЛТАЙ

000938